



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 366

Улаанбаатар хот

「 Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Богд хааны ордны музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 20,077,777.78 (хорин сая далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Богд хааны ордны музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаатар, Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь политехникийн коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загдгочоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай;

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Тогтоолын биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001842

17-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн
166 дугаар тогтоолын хавсралт

БОГД ХААНЫ ОРДОНЫ МУЗЕЙН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦАА,
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Балансад бүртгэлтэй байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Улсын дугаар	Арлын дугаар	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ /хуримдлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах байгууллага
1	Богд хааны ордоны музей	Соната 6 суудлын автомашин	2013-09-30	82-83 УНЭ	КМННУ41М Р8А468723	1	ш	20,077,777.78	2	5,500,000.00	Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехникийн коллежи
Нийт дүн						1		20,077,777.78 (хорин сая далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан найман мөнгө)		5,500,000.00 (таван сая таван зуун мянга)	